

Монгол Улсын нутаг дэвсгэр болон хил орчмын бүс нутагт болж буй гамшиг, аюулт үзэгдлийн давтамж, урьдчилан сэргийлэх ажиллагаа

Л.Оюунбат

*Дотоод хэргийн их сургуулийн Хилийн албаны сургуулийн
Хилийн албаны тэнхим*

ABSTRACT

There have been many catastrophic events in world history, and Mongolia has not been spared. On December 4, 1957, at 11:30 a.m., a 12-magnitude earthquake struck the Great Bogdo in the Altai Mountains.

Then, researchers named the 5 most likely catastrophic events to occur in the next 50-100 years. 2 of these are earthquakes. These include:

1. A powerful earthquake that would level the city of Istanbul to the ground. Istanbul, once the capital of the Byzantine Empire, is located at the epicenter of a powerful earthquake. Researchers have emphasized that Istanbul, located just over 20 kilometers from the North Anatolian Fault, is likely to be hit by a powerful earthquake and subsequent tsunami in the near future. The last earthquake caused by the fault occurred in 1999, killing about 17,000 people.
2. The San Andreas Fault is a major earthquake zone. Researchers predict that the next major earthquake in the region will occur within the next 30 years, and it is likely to be a magnitude 8 or greater. In addition, earthquakes along this fault, which is located along the west coast of California, are frequent and can even awaken volcanoes.

Keywords: *State borders, border areas, disasters, hazardous phenomena.*

ҮНДСЭН ХЭСЭГ

“Гамшиг” гэж аюулт үзэгдэл, ослын улмаас олон хүний амь нас, эрүүл мэнд хохирох, мал, амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, түүх, соёлын дурсгалт зүйл, хүрээлэн байгаа орчинд улс болон орон нутгийн эдийн засаг, нийгмийн дотоод нөөц, боломжоос давсан хохирол учрахыг хэлнэ.¹

Гамшиг (disaster) гэдгийг бусад эрх зүйн баримт бичгүүдэд:

1. “их хэмжээний хохирол, гарз, сүйрлийг авчрах гэнэтийн аюултай үзэгдэл”²
2. “байгалийн болон хүний үйл ажиллагаатай холбоотой аюулын улмаас их хэмжээний хохирол, сүйрэл учрах, хүний амь нас үрэгдэх болон хүрээлэн буй

¹ Монгол Улсын Гамшигаас хамгаалах тухай хууль. УБ., 2017 он

² Вэбстерийн толь бичиг

орчинд эрс өөрчлөлт орох нөхцөл үүсэхийг”³

3. “ган зуд, үер ус, өвчин тахал, дайны хөнөөл зэрэг аюул: гамшиг болох (аюул тохиолдох)-ыг хэлнэ”⁴ хэмээн тодорхойлжээ.

Гамшиг нь учруулсан хохирол ба нэрвэгдэгсдийн хор уршгийг арилгах арга хэмжээг хэрэгжүүлэхэд тухайн нийгмийн чадавхаас хэтэрсэн үзэгдэл тохиолдох гэсэн утгаар гол төлөв тодорхойлогдож байна.⁵

Гамшиг, аюулт үзэгдэл, аюул, осол, онцгой байдал гэсэн ойлголтуудыг хэрхэн ойлговол зохих бэ?

Улс орон бүр өөрийн онцлогт тохируулан гамшиг гэдэг ойлголтыг өөр өөрөөр тодорхойлдог боловч ерөнхийдөө нэрвэгдсэн хүн ам, улс орон дан ганц өөрийн нөөц хүч хөрөнгөөр хор уршгийг нь арилгах боломжгүй, хүн ам, материаллаг баялаг, хүрээлэн байгаа орчинд их хэмжээний хохирол учруулж, нийгмийн хэвийн амьдралыг удаан хугацаагаар алдагдуулсан үзэгдэл гэж тодорхойлдог.

Харин аюул гэдэг нь гамшиг болохуйц хэмжээнд хүний амь нас, эд хөрөнгө эсвэл үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж байгаа байгалийн буюу хүний зохисгүй үйл ажиллагаатай холбоотой ховор тохиолдох ноцтой үйл явдлыг хэлнэ.

Гамшиг=аюулт үзэгдэл+эмзэг байдал. Жишээ нь:-тодорхой бүлэг хүмүүс ширүүн, догшин гол мөрний нөлөөнд эсвэл галт уулын дэлбэрэлт, газар хөдлөлтөд өртөх эмзэг газар суурьшсанаас гамшиг бий болно. Харин үер, галт уул дэлбэрэх, газар хөдлөх зэрэг нь өөрсдөө гамшиг биш. Өөрөөр хэлбэл хүн ам суурьшаагүй эзэнгүй газар болсон үер, галт уулын дэлбэрэлт, газар хөдлөлт зэрэг нь байгалийн үзэгдэл болохоос гамшиг биш юм. “Эмзэг байдал” гэж аюулд хүн ам, мал, амьтан, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчин өртөгдөх зэргийг хэлнэ.⁶

Дэлхийн уур амьсгал сүүлийн хэдэн жилд ихээхэн өөрчлөгдөж байгаагаас шалтгаалан манай оронд тохиолддог гамшгийн давтамж ойртож, хугацаа нь уртсаж гамшиг, аюулт үзэгдлийн улмаас учрах хохирол нэмэгдэж байна.

Манай орны хувьд газар хөдлөлт, үер, хүчтэй салхи, цасан болон шороон шуурга, ган, зуд, ой хээрийн түймэр, үйлдвэрийн осол, хүн, малын гоц халдварт өвчин, хортон мэрэгчид тархах, хорт бодис алдагдах зэрэг гамшиг, аюулт үзэгдэл бусдаас харьцангуй олон тохиолддог.

“Аюулт үзэгдэл” гэж хүчтэй цасан болон шороон шуурга, ган, зуд, үер, аянга, газар хөдлөлт, гал түймэр, хүн, мал, амьтны гоц халдварт өвчин гарах, хортон шавж, мэрэгч тархах зэргийг хэлнэ.⁷

Монгол Улсын нутаг дэвсгэрийн зах хязгаарыг газрын гадаргуу, усны мандал дээр хил залгаа улсын нутаг дэвсгэрийн хязгаараас зааглаж Монгол Улсын олон улсын гэрээгээр тодорхойлж, тогтоосон шугамыг Монгол Улсын хил /цаашид «улсын хил» гэх/ гэнэ. Уг шугамаас эгц дээш агаарын, мөн шугамаас эгц доош

³ Википедиа тайлбар толь

⁴ Монгол хэлний их тайлбар толь

⁵ Quarantelli, 1984 он; Perry, 1991 он; Tierney, Lindell & Perry, 2001 он

⁶ Монгол Улсын Гамшигаас хамгаалах тухай хууль. 4.1.6. УБ., 2017 он

⁷ Монгол Улсын Гамшигаас хамгаалах тухай хууль. УБ., 2017 он

газрын хэвлийн хил байна.⁸

Улсын хилийн дэглэмийг сахиулах, улсын хил хамгаалалт, шалган нэвтрүүлэх албыг зохион байгуулах, хилийн инженер, техникийн байгууламж барих зориулалтаар улсын хилийн шугамаас дотогш 15 км-ээс илүүгүйгээр тусгай журам тогтоосон нутаг дэвсгэрийг улсын хилийн зурвас гэнэ.⁹

Хил залгаа улстай хиллэж байгаа сумын нутаг дэвсгэрийг хил орчмын нутаг дэвсгэр гэнэ.¹⁰

Хилийн зурвас гэж “...хилийг дэглэмийг сахиулах, хамгаалах, шалган нэвтрүүлэх албыг зохион байгуулах, техникийн барилга, байгууламж барих зориулалтаар хилийн шугамаас дотогш 15 км-ээс илүүгүй тусгай журам тогтоосон нутаг дэвсгэр” юм.

Хилийн бүс гэж “...хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах, урьдчилан сэргийлэх зорилгоор тусгай журмаар тогтоосон хилийн шугамаас 100 км-ээс илүүгүй орон зай” юм.

Хил орчмын нутаг дэвсгэр гэж “...хил залгаа улстай хиллэж байгаа сумын нутаг дэвсгэр”-ийг хэлнэ.

Улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдал, хамгаалах асуудал нь дан ганц хил хамгаалах байгууллага, хилийн тухай хуулиар шийдвэрлэх, зохицуулах асуудал биш юм.¹¹

Монгол оронд тохиолдож байгаа гамшиг, аюулт үзэгдлээс хамгийн анхаарал татаж байгаа нь газар хөдлөлтийн гамшиг бөгөөд газар хөдлөлтийн давтамж, хүч нь нэмэгдэж, энэ тал дээр бид бэлтгэл, бэлэн байдлаа сайжруулах шаардлага үүсэж байгааг албаны хүмүүс онцлон тэмдэглэж байна.

Монгол Улсын нутаг дэвсгэрийн хил орчмын бүсэд 2011 оноос хойш өнөөдрийг хүртэл 118,900 удаагийн газар хөдлөлт болсон. Тэр дундаа 3,5 буюу түүнээс дээш магнитудын хүчтэй газар хөдлөлт 1628 удаа бүртгэгджээ. Дээрх хугацаанд мөн 6 магнитудын хүчтэй газар хөдлөлт 3 удаа болсон байна. Тиймээс ч Монгол Улс газар хөдлөлтийн гамшигт нэрвэгдэх эрсдэл маш өндөртэй улсын тоонд орж байгаа нь бидний санаа зовох асуудал зүй ёсоор болжээ.

Монгол орны нутаг дэвсгэр болон хил орчмын бүс нутагт 2019 онд нийтдээ 45757 газар хөдлөлт болсноос (Зураг 1) Монгол орны нутаг дэвсгэрт 30100 газар хөдлөлт, хил орчмын бүсэд 15657 газар хөдлөлт болсон байна. Эдгээрийг хүчний хувьд ялган авч үзвэл:

- Магнитуд нь $M < 1.0$ газар хөдлөлт 23821,
- Магнитуд нь 1-тэй газар хөдлөлт 17723,
- Магнитуд нь 2-той газар хөдлөлт 4034,
- Магнитуд нь 3-тай газар хөдлөлт 152,

⁸ МУХТХ. 4.1. УБ., 2016 он

⁹ МУХТХ. 26.1. УБ., 2016 он

¹⁰ МУХТХ. 30.1. УБ., 2016 он

¹¹ “Үндэсний хөгжил” судалгааны ажлын хэлэлцүүлэг. УБ., 2021 он

- Магнитуд нь 4-тэй газар хөдлөлт 23,
- Магнитуд нь 5-тай газар хөдлөлт 4 удаа тус тус болсон байна.

Монгол орны нутаг дэвсгэр болон хил орчмын бүс нутагт магнитуд нь 3.5 болон түүнээс дээш хүчтэй газар хөдлөлт 55 удаа болсон.

Монгол орны нутаг дэвсгэр болон хил орчмын бүс нутагт 2020 онд нийтдээ 64765 газар хөдлөлт болсноос (Зураг 2) Монгол орны нутаг дэвсгэрт 44462 газар хөдлөлт, Монгол орны хил орчмын бүсэд 20303 газар хөдлөлт болсон. Эдгээрийг хүчний хувьд ялган авч үзвэл:

- Магнитуд нь $M < 1.0$ газар хөдлөлт 38537,
- Магнитуд нь 1-тэй газар хөдлөлт 22983,
- Магнитуд нь 2-той газар хөдлөлт 3059,
- Магнитуд нь 3-тай газар хөдлөлт 143,
- Магнитуд нь 4-тэй газар хөдлөлт 38,
- Магнитуд нь 5-тай газар хөдлөлт 5 удаа тус тус болсон байна.

Монгол орны нутаг дэвсгэрт магнитуд нь 3.5 болон түүнээс дээш хүчтэй газар хөдлөлт 63 удаа болсон байна.

Монгол орны болоод хил орчмын бүс нутагт болсон газар хөдлөлтийн төвийн тархалт болоод хүчнийх нь хувьд дүн шинжилгээ хийж үзэхэд тус бүс нутагт орших тектоник идэвхтэй хагарлуудын дагуу Монгол Алтай нурууны өмнөд төгсгөл хэсэг болох Дарви, Хан Тайшир, Хар Азарга болон Гичгэнийн нурууны бүс нутгууд, Хөх Сэрхийн нуруу, Чуй, Могод, Бүсийн гол, Тахийн шар, Үүрэг нуур болон Цагаан шувуут, Мөнххайрхан, Булнай, Могод, Дэрэн, Бүтээлийн нуруу зэрэг идэвхтэй бүсүүдийн дагуу газар хөдлөлийн идэвхжилт өнөөг хүртэл ажиглагдсан хэвээр байна.

2020 оны байдлаар Монгол Алтай, Говь-Алтай, Булнай, Могодын идэвхтэй хагарлын бүс нутгуудад газар хөдлөлтийн идэвхжил нэлээд ажиглагдлаа. Тухайлбал Говь-Алтай болон Монгол Алтайн идэвхтэй хагарлын системийн уулзвар болох Тонхилын хагарлын бүс нутагт 2020 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 11 цаг 03 минут 12 секундэд (Улаанбаатарын цагаар) магнитуд нь 5.8-тай газар хөдлөлт болсон. Тус газар хөдлөлт нь голомтдоо VI-VII баллын хүчтэй чичирхийлэл үүсгэсэн ба баруун аймгуудын ихэнх нутаг дэвсгэрт, тухайлбал Говь-Алтай аймгийн төв болон ихэнх сумд, Ховд, Завхан, Баян-Өлгий аймгийн төв болон зарим сумын ард иргэдэд мэдрэгдсэн байна. Уг хүчтэй газар хөдлөлтөөр өдөөгдсөн газрын гүн дэх эвдрэлийн процесс эрчимтэй явагдаж улмаар тухайн бүс нутагт олон тооны давталт газар хөдлөлтүүд болж байна. Магнитуд нь 3.5 болон түүнээс дээш хүчтэй газар хөдлөлт 7 удаа болсон байна.

2021 он гарсаар Монгол орны нутаг дэвсгэрт магнитуд нь 3.5 болон түүнээс дээш хүчтэй газар хөдлөлт 12 удаа болсон ба 6 магнитудын газар хөдлөлт 2 удаа болсон. Энэ нь сүүлийн 10 жилд болсон газар хөдлөлтийн дундаж үзүүлэлттэй харьцуулахад нийт газар хөдлөлт 5.7, хүнд мэдрэгдэх хэмжээний газар хөдлөлт 6 дахин өссөн байна. Хөвсгөл аймгийн Ханх суманд болсон хүчтэй газар хөдлөлтийн давталт 176 удаа болжээ.

2022 онд “Монгол орны нутаг дэвсгэрт 58266 удаа газар хөдлөлт болж, үүнээс хүнд мэдрэгдэх хэмжээний буюу 3.5 магнитуд болон түүнээс дээш хүчтэй газар хөдлөлт 134, түүний дотор 5-5.9 магнитудын хүчтэй газар хөдлөлт 3 удаа болсон. Энэ үзүүлэлтийг сүүлийн 10 жилийн хугацаанд Монгол Улсын нутаг дэвсгэрт болсон газар хөдлөлтийн дундаж үзүүлэлттэй харьцуулахад нийт газар хөдлөлт 5.7, хүнд мэдрэгдэм газар хөдлөлт 6 дахин өссөн.

Өөр нэгэн эх сурвалжид тэмдэглэснээр Монгол орны нутаг дэвсгэр болон хил орчмын бүс нутагт 67.664 удаагийн газар хөдлөлт болсон байна. Үүнээс манай улсын нутаг дэвсгэрт 45.058 газар хөдлөлт, хил орчмын бүсэд 22.506 газар хөдлөлт, хүнд мэдэгдэх хэмжээний 3.5 магнитуд болон түүнээс дээш хүчтэй газар хөдлөлт 22 удаа болжээ.

Монгол орны нутаг дэвсгэр болон хил орчмын бүс нутагт 2023 оны нэгдүгээр сараас гуравдугаар сарын 16-ны хооронд нийт 42046 газар хөдлөлт болсон байна. Харин 2024 он гарсаар эхний гурван сарын байдлаар 261 газар хөдлөлт болсон ба магнитуд нь 3.5 болон түүнээс дээш хүчтэй газар хөдлөлт 17 удаа болжээ.

2024 оны байдлаар Монгол орны нутаг дэвсгэр болон Улсын хил орчмын бүс нутагт нийтдээ 38304 газар хөдлөлт болсон байна. Эдгээр газар хөдлөлтүүдээс Монгол орны нутаг дэвсгэрт 22610 газар хөдлөлт болсон бөгөөд эдгээр газар хөдлөлтүүдийг хүчнийх нь хувьд ялган авч үзвэл:

- Магнитуд нь 1 хүртэлх ($ML < 1.5$) газар хөдлөлт 17505 удаа,
- Магнитуд нь 2-той ($1.5 \leq ML \leq 2.4$) газар хөдлөлт 4784 удаа,
- Магнитуд нь 3-тай ($2.5 \leq ML \leq 3.4$) газар хөдлөлт 284 удаа,
- Магнитуд нь 4-тэй ($3.5 \leq ML \leq 4.4$) газар хөдлөлт 36 удаа,
- ҮМагнитуд нь 5-тай ($4.5 \leq ML \leq 5.4$) газар хөдлөлт 1 удаа болсон байна.

2024 онд Монгол орны нутаг дэвсгэр болон улсын хил орчмын бүс нутагт бүртгэгдсэн газар хөдлөлтийн тархалтын мэдээг Одон орон, геофизикийн хүрээлэнгийн боловсруулсан зургаас харж болно (Зураг 4).

Газар хөдлөлтийн хүч буюу магнитуд нь 5 болон түүнээс дээш хүчтэй болсон тохиолдолд GNSS-ийн байнгын ажиллагаатай суурин станцад бүртгэгддэг.

Газар зохион байгуулалт геодези зураг зүйн ерөнхий газар /ГЗБГЗЗБГ/ нь Шинжлэх ухааны академийн Одон орон, геофизикийн хүрээлэнтэй хамтран ажиллах гэрээний хүрээнд тус газрын GNSS-ийн байнгын ажиллагаатай суурин станцын статик өгөгдлөө хуваалцаж судалгааны үр дүнг хамтран боловсруулдаг.

GNSS-ийн байнгын ажиллагаатай суурин станцын хэрэглээний нэг салбар бол байгалийн гамшигт үзэгдэл тэр дундаа хүчтэй газар хөдлөлтийн нөлөөгөөр нутаг дэвсгэрийн хавтан шилжих, газрын гадаргад өргөлт, суулт, хэвтээ босоо тэнхлэгийн дагуу өөрчлөлт гарах зэргийг газар хөдлөлт үүсэхээс өмнөх болон дараах байдлаар тодорхойлдог.

Газар хөдлөлтийн хүчийг 8 магнитуд, 12 баллын үнэлгээ шаталбараар үнэлдэг байна. Магнитуд гэдэг нь хөрсөн доор, газар хөдлөлт болж байгаа төв хэсгийг хэмжиж байгаа үзүүлэлт бол газрын хөрсөн дээр буюу хүнд болон байрилга

байгууламжид мэдрэгдэж байгааг баллаар хэмждэг ажээ.

2.5 магнитуд зөвхөн багажид бичигдэнэ.

2.5-5.4 магнитуд хүн мэдрэнэ, ялигүй гэмтэл үүсэж болно

5.5-6.0 магнитудад бага зэргийн эвдрэл учруулна.

6.1-6.9 магнитудад хүчтэй бол хот суурин газар эвдрэл учруулна

7.0-7.9 магнитудад хүчтэй эвдрэл сүйтгэл их,

8 магнитудаас дээш хүчтэй газар хөдлөлт болоход маш хүчтэй буюу Эпицентрийн ойролцоо бүрэн сүйрнэ гэж үздэг байна.

Улсын хил орчмын нутаг дэвсгэрт гамшгаас хамгаалах үйл ажиллагааны өнөөгийн байдал буюу хил орчмын нутагт гамшгаас хамгаалах ажиллагаа.

Дэлхий дахинаа газар хөдлөлт судлаачдын ганц зорилго нь газар хөдлөлтийг урьдчилан хэлэх. Гэтэл одоо дэлхийн ямар ч эрдэмтэн газар хөдлөлтийг урьдчилж хэлээгүй байна. Гэхдээ нөхцөлүүдийг ажиглаж болдог, хөрс усны түвшин дээшлэх зэрэг хяналтуудыг хийж болдог. Онолын түвшинд судалгааны ажлууд явагдаж байна.

Монгол Улсын Гамшгаас хамгаалах тухай, Галын аюулгүй байдлын тухай, Улсын нөөцийн тухай, Ой хээрийн түймрээс хамгаалах тухай, Хилийн тухай хууль, Засгийн газрын 2011 оны 340 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт буюу “гамшгийн үед хүч хэрэгслийг дайчлан гаргах журам”, 2 дугаар хавсралт буюу “гамшгийн үед нүүлгэн шилжүүлэх журам” болон бусад эрх зүйн баримт бичгүүдийн хүрээнд гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах ажил зохион байгуулагддаг.

Хойд хөрш Оросын Холбооны Улстай 1995 оны 2 дугаар сарын 11-ний өдөр Хил орчмын нутаг дэвсгэрт үйлдвэрийн осол, байгалийн гамшгаас урдчилан сэргийлэх, үр дагаврыг арилгах чиглэлээр, Бүгд Найрамдах Хятад Ард Улстай 1999 оны 07 дугаар сарын 15-ны өдрийн Хил орчмын ой, хээрийн түймэртэй тэмцэх чиглэлээр тус тус гэрээ байгуулсан.

Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хооронд: Иргэд харилцан зорчих журмын тухай Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр” /1989 он/; “Монгол, Хятадын хилийн боомт, тэдгээрийн дэглэмийн тухай Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр” /2004, 2020 он/; “Монгол, Хятадын хилийн дэглэмийн тухай Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын гэрээ” /2010 он/ байгуулсан.

Монгол Улс, БНХАУ-ын Хил хамгаалах байгууллагуудын хооронд: “Монгол Улсын ХЦУГ, БНХАУ-ын НАХЯ-ны Хил хамгаалалтын газрын итгэмжлэгдсэн төлөөлөгчдийн харилцан ажиллах журмын тухай санамж бичиг” /1997.11.24/; “Монгол Улсын ХЦУГ, БНХАУ-ын Батлан хамгаалах яамны хооронд Хил хамгаалалтын талаар хамтран ажиллах тухай хэлэлцээр” /1999.11.09/; “Монгол Улсын ХХЕГ, БНХАУ-ын НАХЯ-ны ХЦУГ-ын хооронд “Хилийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хил дамнасан хууль бус үйлдлийг таслан зогсоох ажиллагааг эрчимжүүлэх тухай санамж бичиг” /2010.08.27/; “Монгол Улсын ХХЕГ, БНХАУ-ын НАХЯ-ны Хилийн цэргийг удирдах газар хоорондын хилийн дэглэм сахиулах

хамтын ажиллагааны санамж бичиг” /2017 он/; “Улсын хил хамгаалалтын талаар хамтран ажиллах тухай Монгол Улсын ХХЕГ, БНХАУ-ын Батлан хамгаалах яам хоорондын хэлэлцээр” /2019.09.07/; “Монгол Улсын ХХЕГ, БНХАУ-ын Улсын Цагаачлалын удирдах газар хоорондын Хилийн боомтын хууль сахиулах хамтын ажиллагааны санамж бичиг” /2021.12.14/ зэрэг эрх зүйн баримт бичгүүдийг удирдлага болгон Хил хамгаалах байгууллага, онцгой байдлын хамтын ажиллагаа явгадагддаг.

Монгол Улсын Хил хамгаалах болон онцгой байдлын байгууллагуудын удирдлагын түвшинд өнөөгийн байдлаар хамтын ажиллагааны чиглэлээр эрх зүйн ямар нэгэн баримт бичиг байхгүй боловч хил дагуу аймгуудын онцгой байдлын газар, хэлтсүүдтэй хилийн анги, нэгтгэлүүд хамтын ажиллагааны гэрээ байгуулж болзошгүй гамшгаас хамгаалах бэлэн байдлын төлөвлөгөө боловсруулан түүнийхээ дагуу хамтран ажиллаж байна.

Хилийн болон хил орчмын нутаг дэвсгэрт гамшиг, аюулт үзэгдэл, ослоос хамгаалах ажиллагаа. Хилийн бүс, зурваст бий болсон гамшиг, аюулт үзэгдэлтэй тэмцэх нь хариуцсан хэсгийн хил хамгаалалтыг тасралтгүй явуулах, тухайн нөхцөлийг далимдуулан гарч болох хилийн зөрчил будлианаас урьдчилан сэргийлэх, бие бүрэлдэхүүний аюулгүй байдлыг хангах, бий болсон гамшиг аюултай тэмцэх, түүний хор хөнөөлийг арилгахад чиглэгдсэн зайлшгүй гүйцэтгэх арга хэмжээ болно. Хилийн отряд, застав, харуулын байнгын байрлалын ойролцоо буюу хилийн зурвас, бүсэд гамшиг, аюулт үзэгдэл тохиолдсон, түүнд хилчид, хил хамгаалах байгууллагын байрлал, эд хөрөнгө, инженер, техникийн байгууламж өртсөн тохиолдолд түүнтэй тэмцэх ажиллагаанд хилийн отряд оролцож, мэргэжлийн болон харилцан ажиллагаатай байгууллагуудын хүч оролцоог өргөнөөр ашиглана.

Гамшиг, аюулт үзэгдэл гарсан тохиолдолд хилийн отряд нь улсын хил хамгаалалтын үүргийг сулруулахгүй байх, гамшиг, аюулт үзэгдэлтэй тэмцэх арга хэмжээг цагийн байдлын дагуу төлөвлөн аврах, хор уршгийг арилгах, сэргээн босгох үйл ажиллагааг цаг алдалгүй хэрэгжүүлэх, түүнд оролцох харилцан ажиллагаатай байгууллагууд, болон иргэдийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, бие бүрэлдэхүүн, голомтод ажиллаж байгаа бүлгүүдийн аюулгүй байдлыг сахих, бусад хэсэгт гамшиг, аюулт үзэгдлээс урьдчилан сэргийлэхэд гол анхаарлаа чиглүүлнэ.

Хилийн бүс, зурваст гамшиг, аюулт үзэгдэл тохиолдсон тухай мэдээ авагдсан тохиолдолд хилийн отрядын дарга уг мэдээллийг магадлан шалгаж, бодитой болох нь тогтоогдвол Хил хамгаалалтыг удирдах төрийн захиргааны байгууллагын даргад нэн даруй илтгэнэ.

Хилийн бүс, зурваст гамшиг, аюулт үзэгдэл болсон үед хилийн отрядын дарга орон нутаг дах онцгой байдлын асуудал хариуцсан алба, харилцан ажиллагаатай байгууллагуудтай мэдээлэл солилцож, мэргэжлийн байгууллагуудын оролцоотойгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох бөгөөд энэ чиглэлээр хил залгаа улсын хил хамгаалах байгууллагатай хамтран ажиллаж болно.

Хилийн бүс, зурваст гамшиг, аюулт үзэгдэл болсон үед гамшиг, аюулт үзэгдлээс хамгаалах хилийн отрядын урьдчилсан ажиллагааны төлөвлөгөө, Хил

хамгаалалтыг удирдах төрийн захиргааны байгууллагын даргын өгсөн үүргийн дагуу отрядын дарга улсын хил хамгаалалтыг ямар хэлбэр, зааг, хүч хэрэгслээр өөрчлөн зохион байгуулах шийдвэрийг шинээр боловсруулан хэрэгжүүлнэ.

Ер нь хоногийн 24 цагийн хугацаанд 300-гаад газар хөдлөлт Монгол орны нутаг дэвсгэр болоод хил орчмын бүс нутагт болж байдаг. Иргэд мэдэрдэггүй. Энэ нь зөвхөн багажид мэдрэгдэж байгаа зүйл. Иргэд хүчтэй хөдлөлт мэдрээд ирэхээрээ л газар хөдлөлт ихсээд байна гэж ойлгож байна. Газар хөдлөлт нь хоромхон зуур болдог учир хүний биед ямар нэгэн шинж тэмдэг илрэхгүй. Харин хүчтэй газар хөдлөлтийн өмнө геофизикийн орон өөрчлөгдөх, газрын гүний усны төвшин дээшлэх магадлалтай тул газар доор байгаа амьтад газрын гадаргуу руу гарах гэж тэмүүлдэг. Мөн газар хөдлөхийн өмнө хүчтэй шахалтын улмаас хавтан хоорондын үрэлтээр хүнд сонсогдож мэдрэгдэхгүй ч гэрийн тэжээвэр амьтанд сонсогдох чимээ нь тухайн газраас зугтах, явахад хүргэдэг байна. Энэ мэт шинж тэмдгүүдийг эрт дээр үеэс ашиглаж сэрэмжилж ирсэн байдаг. Тэгэхээр иймэрхүү үзэгдлүүдийг сайн ажиглаж байх хэрэгтэй гашгаас өөрийгөө болон бусдын амь нас, эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх арга ажиллагаа болно.

ДҮГНЭЛТ

Аливаа улс орон гамшгаас хамгаалах арга хэмжээг хэрхэн зөв, шуурхай, зохион байгуулалттай авч хэрэгжүүлж байгаа түүнд хэр зэрэг ач холбогдол өгч байгаа зэрэг нь учирч болзошгүй хохирлын хэмжээг бууруулахад томоохон нөлөө үзүүлдэг байна. Иймд гамшгаас хамгаалах арга хэмжээнд ихээхэн анхаарвал зохино. Гамшгийн хор хөнөөлийг арилгах, чадавхыг бэхжүүлэх үйл ажиллагаанд тогтмол чухлаар тавигдаж байдаг асуудлууд бол өндөр хүчин чадал бүхий тоног төхөөрөмж, техникийн хэрэгслийн хэрэгцээ шаардлага, гамшгийн үеийн эрэн хайх, аврах ажиллагааг боловсронгуй болгох Монгол Улсын Хил хамгаалах байгууллагын болон орон нутгийн ажилтан, албан хаагчдын чадавхыг бэхжүүлж, цаашдын үр ашигтай ажиллагааг өргөжүүлэх явдал юм.

Хил орчмын нутаг дэвсгэрт гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр Хил хамгаалах байгууллага болон Онцгой байдлын байгууллага, хувийн хэвшил, нутгийн иргэдийн оролцооны уялдааг зохион байгуулах арга хэмжээг сайжруулах нь чухал гэж үзэж байна.


АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Монгол Улсын Гамшгаас хамгаалах тухай хууль. Уб., 2017 он
2. Монгол Улсын Хилийн тухай хууль. Уб., 2016 он
3. Монгол Улсын Хил хамгаалалтын дүрэм. Уб., 2016 он
4. “Үндэсний хөгжил” судалгааны ажлын хэлэлцүүлэг. Уб., 2021 он
5. Вэбстерийн толь бичиг
6. Википедиа тайлбар толь
7. Монгол хэлний их тайлбар толь
8. Quarantelli, 1984 он; Perry, 1991 он; Tierney, Lindell & Perry, 2001 он
9. Ё.Хадхүү. Хилийн болон хил орчмын нутаг дэвсгэрт гамшиг, аюулт үзэгдлээс хамгаалах ажиллагаа. Уб., 2024 он


ХАВСРАЛТ




Зураг 1. Монгол орны нутаг дэвсгэр болон хилийн ойролцоох бүс нутагт болсон газар хөдлөлтийн төвийн тархалтын зураг (2019 оны 12 сарын 31-ний байдлаар).



Зураг 2. Монгол орны нутаг дэвсгэр болон хилийн ойролцоох бүс нутагт болсон газар хөдлөлтийн төвийн тархалтын зураг (2020 оны 12 сарын 31-ний байдлаар).



Зураг 3. Монгол Улсын нутаг дэвсгэр болон Хил орчмын нутаг дэвсгэр дэх газар хөдлөлтийн тархалтын зураг



Зураг 4. 2020 онд тус бүс нутагт болсон газар хөдлөлтийн төвийн тархалтын зураг. (Ногоон өнгөөр 2020 оны 1 дүгээр сарын 1-нээс 3 дугаар сарын 20-ныг хүртэлх, улаан өнгөөр 3 дугаар сарын 20-ноос хойш болсон газар хөдлөлтийг тэмдэглэв.)